



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМ



JFPR
Japan Fund for Prosperous and
Resilient Asia and the Pacific



Боловсролын
Хамтын Ажиллагааны
Пийгэмлэг

ТЭГШ ХАМРАН СУРГАХ БОЛОВСРОЛД

Хамтдаа

Улаанбаатар
2022



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМ



Боловсролын
Хамтын Ажиллагааны
Нийгэмлэг

ТЭГШ ХАМРАН СУРГАХ БОЛОВСРОЛД

Хамтгаа



ННА 74
ДАА 370
Б-559

Энэхүү эцэг эх, олон нийтэд
зориулсан гарын авлагыг “Тэгш хамруулах
боловсролыг дэмжих төсөл”-ийн хүрээнд
боловсруулан хэвлүүлэв.

Боловсруулсан:
Б.Болорчимэг (Төслийн зөвлөх багийн ахлагч,
магистр)
Ч.Жаргал (Докторант)
Зураач:
А.Нямбаатар

ISBN: 978-9919-9963-0-7

ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Боловсрол, шинжлэх ухааны яам нь Азийн Хөгжлийн Банктай хамтран Цэцэглэн хөгжсөн, сөрөг нөлөөнд тэсвэртэй Ази, Номхон далайн бүс нутгийг цогцлоох Японы сангийн тусламжаар “Тэгш хамруулах боловсролыг дэмжих төсөл”-ийг 2021-2024 онд хэрэгжүүлж байна. Уг төслөөр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролын чанар, хүртээмжийг сайжруулахыг зорьж байна. Уг төсөл нь дараах 3 бүрэлдэхүүн хэсэгтэй:

ЗОРИЛТ 1.

Ердийн цэцэрлэг, сургуулийн барилга байгууламжийн хүртээмжтэй байдлыг сайжруулах

ЗОРИЛТ 2.

Тэгш хамран сургах боловсролын үйлчилгээг хүргэх чадавхыг бэхжүүлэх

ЗОРИЛТ 3.

Тэгш хамран сургах боловсролыг дэмжих нөөц боломж, олон нийтийн оролцоо болон бодлогыг сайжруулах

ГАРЫН АВЛАГЫН ТУХАЙД

Энэхүү гарын авлагыг тэгш хамран сургах боловсролын ач тус, үр нөлөөг олон нийтэд таниулан сурталчлах, энэ талаарх үйл ажиллагаанд тэдний оролцоо, санаачилгыг нэмэгдүүлэхэд дөхөм болох үүднээс уншихад хялбар, энгийн үгээр бичлээ. Хүүхдийн ялгаатай байдлыг хүндэтгэн, хүлээн зөвшөөрч, тэднийг дэмжин хөгжүүлэхэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй болон бусад эцэг эхчүүдийн хэн, хэн нь адилхан үүрэг хариуцлага үүрч, үр дүнтэй үйл ажиллагаа өрнүүлж, тэгш эрхийг баталгаажуулснаар илүү сайхан нийгмийг ХАМТДАА бүтээнэ.

Гарын авлага 4 үндсэн хэсгээс бүрдэнэ:


- 1 Тэгш хамран сургах боловсрол яагаад чухал вэ?
- 2 Тэгш хамран сургах боловсрол нийгэм, эдийн засаг, хувь хүнд үр нөлөө үзүүлдэг үү?
- 3 Тэгш хамран сургах боловсролыг өргөжүүлэхэд улс орон, олон нийт юу хийх хэрэгтэй вэ?
- 4 Тэгш хамран сургах боловсролыг хөгжүүлэхэд эцэг эх, олон нийтийн оролцоо, хамтын ажиллагааг хэрхэн өрнүүлэх вэ?

ГАРЧИГ

Тэгш хамран сургах боловсрол яагаад чухал вэ?	6
Тэгш хамран сургах боловсрол нийгэм, эдийн засаг, хувь хүнд үр нөлөө үзүүлдэг үү?	10
Тэгш хамран сургах боловсролыг өргөжүүлэхэд улс орон, олон нийт юу хийх хэрэгтэй вэ?	14
Тэгш хамран сургах боловсролыг хөгжүүлэхэд эцэг эх, олон нийтийн оролцоо, хамтын ажиллагааг хэрхэн өрнүүлэх вэ?	23
Ном зүй	46

1. ТЭГШ ХАМРАН СУРГАХ БОЛОВСРОЛ ЯАГААД ЧУХАЛ ВЭ?

ТЭГШЭЭ, ЭРХЭС ХОЁР ТАЙЛБАРЛАЖ БАЙНА.



ТЭГШ ХАМРАН СУРГАХ БОЛОВСРОЛ ЯАГААД ЧУХАЛ ВЭ?



Нэг, нэгнийхээ талаар мэдэж авч, хамтдаа эв найртай байхад нь



Илүү сайн боловсрол эзэмшихэд нь



Бие даан илүү ихийг хийж, илүү олон ур чадварт суралцахад нь



Бусадтай нэгдэх болон нийгмийн идэвхтэй нэгэн гишүүн байхад нь



Цаашид ажил хөдөлмөр эрхэлж, ахуй амьдралаа сайжруулахад нь



Ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч хүн бүр үнэ цэнтэй, чадамжтай хэмээн хүндлэгдэхэд нь

ТЭГШ ХАМРАН СУРГАХ БОЛОВСРОЛ БОЛ:



Аливаа ялгаатай байдлаас үл хамааран бүх хүмүүс хамтдаа суралцах явдал юм.



Цэцэрлэг, сургууль, коллеж, их сургуульд бүгд нэг анги танхимд хамтдаа хичээллэхийг хэлнэ.



Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг бусдаас тусгаарлан тусгай цэцэрлэг, сургуульд эсвэл өөр ангид сургана гэсэн үг биш юм.



Бүх суралцагчдад адил тэгш хандах зарчим юм.



Сурч боловсрох эрхээ эдлэхэд тулгарч буй саадыг арилгах үйл явцын үр дүн юм.



Хүний үндсэн эрх бөгөөд бусад эрхийг бодит болгох арга зам юм.


ТЭГШ ХАМРУУЛАЛТ ГЭЖ ЮУ ВЭ?

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцын Ерөнхий зөвлөмж №4




Гадуурхах

Зөвхөн гаднаа адил харагддаг нийгмийн гишүүд нэг "тойрог"-т багтах боломжтой. Бусад гишүүд тойргийн гадна үлддэг.



Тусгаарлах

Олонхоос өөр нийгмийн гишүүд өөрсдийн тусгай "тойрог"-т байдаг. Энэ тойрог нь олонхын "тойрог"-той хэзээ ч давхацдаггүй.



Интеграцчилах

Цөөнхийн "тойрог" нь олонхын "тойрог"-ийн дотор багтсан ч хамтын ажиллагаа байхгүй.



Тэгш хамруулах

ЦОРЫН ГАНЦ "тойрог" байна. Энэ тойрогт ялгаатай байдлаас үл хамааран бүх хүн багтах ба тэд зорилго, үүрэг хариуцлага нэгтэй.

 Тэгш хамруулах боловсролыг дэмжих төсөл

2. ТЭГШ ХАМРАН СУРГАХ БОЛОВСРОЛ НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ, ХУВЬ ХҮНД ҮР НӨЛӨӨ ҮЗҮҮЛДЭГ ҮҮ?

ТЭГШЭЭ, ЭРХЭС ХОЁР ТАНИЛЦУУЛЖ БАЙНА.





НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

- ✓ Бүх хүний хувьд насан туршдаа бие даан амьдрахад нь хэрэгтэй нийгэм-сэтгэл зүйн гол ур чадваруудыг зөвхөн тэгш хамруулсан орчинд л эзэмших боломжтой.
- ✓ Хүүхдүүд илүү эерэг харилцаатай болж, нийгэмд хүлээн зөвшөөрөгдөх зан үйл, хэм хэмжээний талаар ойлгож, нийгэм-сэтгэл зүйн өндөр цогц чадамжтай болдог.



ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

- ✓ ДНБ-ий алдагдлыг ойролцоогоор **5–7%** бууруулдаг. Нийгмийн халамжид үзүүлэх дарамт багасдаг.
- ✓ Боловсролын зардлыг бууруулдаг. Учир нь тусгай цэцэрлэг, сургуульд **7–9** дахин илүү зардал зарцуулдаг.
- ✓ Тусгай боловсролд хамрагдаж буй 1 суралцагчид зарцуулах зардал ердийн цэцэрлэг, сургуулийнхаас дунджаар **2.5** дахин өндөр байдаг.



БАГШ НАРТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчаас ахиц, амжилт гарна гэсэн илүү өндөр хүлээлттэй байдаг.
- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамран сургах багшийн мэдлэг, ур чадвар сайжирснаар бүх суралцагчдад хүрч ажилладаг.



ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛГҮЙ СУРАЛЦАГЧИД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

- ✓ Ердийн ангид хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцах нь бусад хүүхдийн хичээлдээ зарцуулах цаг болон гүйцэтгэлийн түвшинд сөргөөр нөлөөлдөггүй.
- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй найзалж нөхөрлөдөг хүүхдүүд тэднийг илүү ойлгон дэмжиж хамтрах хүсэл эрмэлзэлтэй, бусдын төлөө санаа тавьдаг хүнлэг иргэн болдог.
- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд суралцахад нь тусалдаг хүүхэд илүү гүнзгий мэдлэг, ур чадварыг эзэмшдэг.



ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ СУРАЛЦАГЧИД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй болон бэрхшээлгүй суралцагчид хамтдаа суралцах нь энгийн харилцааны ур чадвар, хөдөлгөөний хөгжил, урам зоригийг нэмэгдүүлдэг.
- ✓ Тэгш хамруулсан орчинд тэд илүү туршлагатай болж, нийтийн дунд байх дуртай болдог.
- ✓ Тусгаарлагдсан орчинд суралцдаг хүүхдүүдтэй харьцуулахад онолын мэдлэг, дадлага туршлага нь илүү хөгждөг.
- ✓ Уян хатан сургалтын хөтөлбөрөөр тэгш хамрагдан суралцсанаар сурлагын амжилт, өөртөө итгэх итгэл нь нэмэгддэг.
- ✓ Боловсрол, нийгмийн харилцаанд идэвхтэй оролцсоноор олон найз нөхөдтэй болж, өөрийн үнэ цэнээ илүү мэдэрдэг.

3. ТЭГШ ХАМРАН СУРГАХ БОЛОВСРОЛЫГ ӨРГӨЖҮҮЛЭХЭД УЛС ОРОН, ОЛОН НИЙТ ЮУ ХИЙХ ХЭРЭГТЭЙ ВЭ?

ТЭГШЭЭ, ЭРХЭС ХОЁР САЛУУЛЖ БАЙНА.



ТЭГШ ХАМРАН СУРГАХ БОЛОВСРОЛЫН ХАРИЛЦАН УЯЛДАА БҮХИЙ 4 ШИНЖ ЧАНАР

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцын Ерөнхий зөвлөмж №4

A

AVAILABILITY

**ХҮРЭЛЦЭЭТЭЙ
БАЙХ**

A

AVAILABILITY

**ХҮРТЭЭМЖТЭЙ
БАЙХ**

A

AVAILABILITY

**ХҮЛЭЭН
ЗӨВШӨӨРӨГДСӨН
БАЙХ**

A

AVAILABILITY

**УЯН ХАТАН
БАЙХ**

Боловсролын тогтолцоо нь хувь хүн бүрийн өвөрмөц давуу тал, авьяас чадварыг хөгжүүлэх боломжийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх бөгөөд дээрх харилцан уялдаатай 4 шинж чанарыг агуулсан байх ёстой.



ЮУ ХИЙХ ХЭРЭГТЭЙ ВЭ?

-  Боловсролд өөрчлөх шаардлагатай бүхий л зүйлсийг тунгаан эргэцүүлэх.
-  Хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон тэдний эрхийг бусад хүмүүс эергээр хүлээж авдаг байх.
-  Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүд боловсролын талаар мэдээлэл сайтай байх.
-  Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст бүх зүйл хэрэглэхэд нь хялбар байх.
-  Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч хөгжих хэрэгцээг аль болох бага насанд нь тодорхойлж, эрт дэмжлэг үзүүлэх.
-  Хүн бүрд суралцах, бусадтай нэгдэх, аливаа зүйлийг хамгийн сайнаараа хийхэд нь шаардлагатай дэмжлэг үзүүлдэг байх.
-  Боловсрол, сургалтын байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй хүн бүрд дэмжлэг үзүүлэхийн тулд тохирох өөрчлөлт хийдэг байх.
-  Хүн бүр өөртөө тохирсон хэв маягаар суралцах боломжийг бүрдүүлдэг байх.



ЮУГ БАТАЛГААЖУУЛАХ ВЭ?

- ✓ Засгийн газрын бүхий л байгууллага тэгш хамран сургах боловсролыг бодит үйл хэрэг болгох чиглэлээр хамтран ажилладаг байх.
- ✓ Тэгш хамран сургах боловсролын талаарх сайн хууль тогтоомж, төлөвлөгөөтэй байх.
- ✓ Хүн бүр сурч боловсрох эрхээ мэддэг, энэ талаар шийдвэр гаргахад идэвхтэй оролцдог байх.
- ✓ Сурч боловсрох эрхээ эдэлж чадахгүй тохиолдолд гомдол гаргах арга зам нь хялбар байх.
- ✓ Бодит байдал ямар байгааг хянаж, өөрчилж сайжруулах арга замаа тодорхойлдог байх.
- ✓ Тэгш хамран сургах боловсролын санхүүжилт хангалттай байх.
- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс тохируулгат өөрчлөлтөөс үүдсэн төлбөр төлдөггүй байх.
- ✓ Албан хаагчид хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн талаарх сургалтад хамрагддаг байх.

ТЭГШ ХАМРУУЛСАН БОДЛОГО

Танай сургууль, цэцэрлэг:

Хамран сургах тойргийн бүх хүүхдийг хөгжлийн бэрхшээл болон бусад ялгаатай байдлаас нь үл хамааран тэгш хамруулах нэгдмэл бодлоготой юу?

Олон нийтийг үйл ажиллагаандаа оролцуулах, байгууллагын хөгжилд хувь нэмэр оруулахад дэмжлэг үзүүлэх төлөвлөгөө, бодлоготой юу?

Тэгш хамран сургах боловсролын талаар зөвлөгөө авах, мэдлэг боловсролоо дээшлүүлэх багш хөгжлийн төлөвлөгөөтэй юү?

Багш, ажилтнууд, эцэг эх, хүүхдүүд бүгд мэддэг бөгөөд хүлээн зөвшөөрсөн байгууллагын “хөгжлийн төлөвлөгөө”-тэй юү?

Ялгаатай бүлгийн хүүхдүүдэд тулгарч буй саад бэрхшээлийг илрүүлж, давж гарахад нь дэмжлэг туслалцаа үзүүлдэг үү?

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролын дараагийн түвшинд шилжин суралцахад нь дэмжлэг үзүүлэх ажлыг бодлого, төлөвлөгөөндөө тусгадаг уу?

БҮХ ЗҮЙЛСИЙГ НЭГЭН ЗЭРЭГ ХИЙЖ ЧАДАХГҮЙ Ч ЗАРИМ ЗҮЙЛСИЙГ НЭН ЯАРАЛТАЙ ХИЙХ ШААРДЛАГАТАЙ.



Эрүүл мэндийн үйлчилгээ сайн байх, нийтийн тээвэр хүртээмжтэй, ашиглахад хялбар байх.



Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гэр орноосоо хол биш харин бусад хүмүүсийн нэгэн адил өөрийн орон нутагтаа амьдрах, суралцах боломжтой байх.



Хүн бүхэнд чанартай боловсрол олгох талаарх төлөвлөгөөтэй байх.



Бүх хүн бага, дунд боловсролын үйлчилгээнд үнэ төлбөргүй хамрагдах.



Боловсролын байгууллагууд тохируулгат өөрчлөлтүүдийг хийснээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хэрэгтэй дэмжлэгээ авдаг байх.



АЛЪ НЬ ЗӨВ БЭ?



Манай хүүхэд ердийн цэцэрлэг, сургуульд хамрагдаж, сурч хөгжиж, нийгэмших эрхтэй.



Манай хүүхэд аутизмтай учир тусгай цэцэрлэг, сургуульд хамрагдах эсвэл гэрээр суралцах л бидний сонголт.



😊😊😊 Тэгш хамран сургах боловсрол нь хөгжлийн бэрхшээл зэрэг ялгаатай байдлыг үл харгалзан бүх хүүхдийг ердийн цэцэрлэг, сургуульд тэгш хамруулж, үеийн найзуудтайгаа хамтдаа суралцаж хөгжихийг дэмждэг. Тиймээс тэгш хамруулсан нийгэм нь тэгш хамруулсан цэцэрлэг, сургуулиас эхэлнэ.



БАРИМТ

2020 оны байдлаар АНУ-ын сургуулийн насны суралцагчдын 95% нь улсын ердийн сургуульд хамрагдаж байсан ба 3% нь улсын болон хувийн тусгай сургуульд, 2% нь төрөөс санхүүжүүлдэг тусгай боловсролын үйлчилгээ бүхий хувийн ердийн сургуульд суралцаж, 1% хүрэхгүй хэсэг нь эмнэлэг, гэр бүлийн асаргаанд эсвэл асрамжийн газар зэрэг тусгайлсан үйлчилгээ үзүүлдэг байгууллагын үйлчилгээнд хамрагдаж байжээ.


Ердийн сургуульд суралцсанаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хувьд нийгэмд тэгш оролцох боломжийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ хөгжлийн бэрхшээлтэй найздаа тусалж буй хүүхэд илүү өөртөө итгэлтэй болж, сурлагын дүн болон харилцааны ур чадвар нь сайжрах зэрэг олон зэрэг нөлөө гардаг байна.





ОНЦГОЙ ХҮМҮҮС

Бидний сайн мэдэх алдарт физикч Альберт Эйнштейнийг аутизмтай байсан байж болзошгүй гэж үздэг байна. Түүнийг хүүхэд байхдаа хожуу хэлд орсон, хүний үгийг дахин давтаж хэлдэг байсан, насанд хүрсэн хойноо бүрэг ичимхий, нийгмийн харилцаанаас зугтаадаг байсан гэдэг. Тэрээр тогтсон хэв маяг, эмх цэгц, ээлж дараалалд дуртай бөгөөд нэг сэдвийг гүн гүнзгий сонирхон судалдаг байсан зэрэг нь аутизмын шинжтэмдэгтэй байсныг илрэл гэнэ.



Э р д э м т э н
эсвэл алдартай нэгэн
болохгүй ч хүн бүр л
тодорхой чадвартай
байдаг болохоор та
хүүхдээ хөгжлийн
бэрхшээлтэй гэдгээс
эмээлгүй мэдлэг
оюунаа өөрийн
түвшинд бүрэн
хөгжүүлж, нийгмийн
үнэт нэгэн гишүүн
болох боломжийг нь
нээж өгөөрэй!

**4. ТЭГШ ХАМРАН
СУРГАХ БОЛОВСРОЛЫГ
ХӨГЖҮҮЛЭХЭД ЭЦЭГ ЭХ,
ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦОО,
ХАМТЫН АЖИЛЛАГААГ
ХЭРХЭН ӨРНҮҮЛЭХ ВЭ?**

ТЭГШЭЭ, ЭРХЭС ХОЁР ЗӨВЛӨЖ БАЙНА.



ХӨГЖЛИЙН ЯЛГААТАЙ ХҮҮХЭДТЭЙ ЭЦЭГ ЭХ, ГЭР БҮЛИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХ 10 АЛХАМ



ҮНЭЛ



Танай хүүхэд юмс үзэгдлийг харж,
таньж байна уу?



Танай хүүхэд дуу авиаг сонсож,
ялгаж байна уу?



Танай хүүхэд хөдөлж, зогсож, явж,
гүйж байна уу?



Танай хүүхэд ярьж, ойлгож, асууж байна уу?



Танай хүүхэд инээж, заримдаа уурлаж
сэтгэл хөдлөлөө илэрхийлж байна уу?

Магадгүй эдгээрээс ганцыг нь эсвэл хоёрыг нь чадахгүй
байлаа гээд **БҮГДИЙГ** чадахгүй гэсэн үг биш шүү дээ.

ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН “4 АЙН” ХҮРЭЭНД АЛЬ ЧАДВАР ДАВУУ, АЛЬ ЧАДВАРТ НЬ АНХААРАХ ХЭРЭГТЭЙГ ҮНЭЛЭЭД ҮЗЭЭРЭЙ.



1. Өөртөө үйлчлэх энгийн чадвар: Хувцсаа өөрөө өмсөх, хоолоо идэх, эд зүйлийг зориулалтаар нь зүй зохистой хэрэглэх гэх мэт өдөр тутмын чадварууд



2. Хэл яриа, танин мэдэхүйн чадвар: Бусдын яриаг сонсож ойлгох, өөрийгөө ойлгуулах, тухайн насанд мэдвэл зохих ерөнхий мэдлэг, зөв бурууг ялган таних чадварууд



3. Нийгэмшихүйн чадвар: Өөрийн болон хүний орон зайг мэдрэх, дараалал баримтлах, баярлаж талархах, найз нөхөдтэйгөө эвтэй тоглох, суралцах, нөхөрлөх чадварууд



4. Бие бялдар, хөдөлгөөний чадвар Өөрийн насанд тохирсон үйлдэл хөдөлгөөнийг тэнцвэр, хурд, эв дүйтэй хийх, чөлөөтэй алхах, гүйх, үзэг харандааг зөв барих, зурлага үсэг дүрслэх чадварууд



ОНЦГОЙ ХҮМҮҮС

“Чимээгүй олимп” буюу “Дифлимп” нэрээр танигдсан Сонсголын бэрхшээлтэй иргэдийн зуны олимпын наадмаас 2009 оны 9 дүгээр сарын 10-ны өдөр Монгол улс анх удаа алтан медаль авчээ. Энэ тамирчин бол 81 кг-ын жинд барилдсан Монгол Улсын гавьяат тамирчин Дамдины Очбадрал байлаа.



2. ЗӨВШӨӨР

Бүх хүн уран гоё зурж, гайхалтай сайхан дуулж, уян налархай бүжиглэж чаддаг бил үү? Танд бас надад чадахгүй зүйл байж л байдаг.

-  Манай хүүхэд бусдаас яагаад хөгжлөөрөө ялгаатай байгаа юм бэ?
-  Хэнээс, юунаас болов? Хэн буруутай вэ?
-  Хүмүүс юу гэх бол, яаж хүлээж авах бол?
-  Би, манайхан яах болж байна аа?
-  Хадмууд, садан төрлүүд юу гэх бол?
- ?

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй гэр бүл, эцэг эхчүүд дээрх асуултуудад хариулт хайсаар цаг хугацаа алдах тохиолдол элбэг байдаг. Бодит байдлыг хүлээн зөвшөөрч, хөгжлийн цогц дэмжлэгийг хэрхэн үзүүлэх талаар мэргэжлийн байгууллага, мэргэжилтнүүдэд аль болох эрт хандах нь хамгийн оновчтой шийдвэр юм.

Бодит байдлаас зугтах биш, нүүр тулж цаашид хэрхэх талаар ярилцаж, шийдэлд хүрэх арга замуудыг сонгоорой.



Үнэлгээ оношилгоог мэргэжлийн төрөлжсөн баг, салбар комиссоор журмын дагуу цаг алдалгүй хийлгээрэй.



Хүүхдийн хөгжлийн төлөвлөгөөг холбогдох мэргэжилтнүүдтэй хамтран гаргаж, цогц дэмжлэгийн үйлчилгээг аль болох эрт аваарай.



Эрт оролцооны хөтөлбөр, хөгжлийн төвүүдийг судлан хүүхдээ нас, биеийн онцлогт нь тохирсон хөтөлбөрт хамруулаарай.



Хүүхэд тань бусадтай яг адил болохгүй ч өчигдрөөс өнөөдөрт, өнөөдрөөс маргаашид илүү хөгжинө гэсэн итгэл хүлээлттэй байгаарай.



Цэцэрлэг, сургуульд хамруулан сургалтын нийтээр хэрэгжүүлэх хөтөлбөр, эсвэл ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөнөөс хүүхдэдээ тохирохыг сонгоорой.



БАРИМТ

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамруулан сургаснаар сургуулийн найзуудын хүрээлэлтэй болох магадлал 3.6%, өрсөлдөхүйц ажлын байртай болох магадлал 11.2%, насанд хүрээд бие даан амьдрах магадлал 10%-аар тус, тус өсдөг байна.



3. СУДАЛ

Хүүхдийн төрсөн цагаас эхлэн ялгаварлан гадуурхалтаас ангид байх, сурч боловсрох эрх, авч хэрэгжүүлж буй бодлого шийдвэрийг нэг бүрчлэн уншиж судлаарай.

Дараах уншиж, судлах материалуудыг танд санал болгож байна.



Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцын Ерөнхий зөвлөмж No. 4

<https://bit.ly/3rO3J7h>



Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль

<https://legalinfo.mn/mn/detail/11711>



Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулахад чиглэсэн эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл

<https://online.pubhtml5.com/pacj/orsr/>

4. ЯРИЛЦ

Ярилцахгүй бол ойлголцохгүй, ойлголцохгүй бол ахиц гарахгүй.



Эн тэргүүнд хүүхдийн хүсэл зоригийг сонсож, итгэл найдвар, урам зоригийг нь асаагаарай.



Хамран сургах тойргийн цэцэрлэг, сургуулийн дэмжлэгийн багтай хүүхдийнхээ талаар тодорхой ярилцаарай.



Хүүхдийнхээ бодит байдал, суралцахад нь тулгарч буй бэрхшээл мөн ахиц амжилтынх нь талаар сар бүр багш болон дэмжлэгийн багаас асууж тодруулаарай.



Хүү, охиныхоо хамт суралцаж байгаа ангийн найз нөхөд, багшид нь талархаж байгаагаа байнга хэлж байгаарай.



Хүүхдэдээ бий болгосон амжилт, туршлагаа хөгжлийн ялгаатай хүүхэдтэй бусад эцэг эхчүүдтэй үргэлж хуваалцаж байгаарай.

Хүүхдийнхээ хөгжил, оролцоог ямар түвшинд байгааг, мөн ямар түвшинд хүргэх ёстойг дараах дүгнэлтээс олж хараарай.



Цэцэрлэг, сургуульд орох: Хүүхэд ердийн цэцэрлэг, сургуульд бүртгүүлж, анги хамт олонд харьяалагдан, биеэр ирж суралцах эхлэл



Оролцох: Хүүхэд анги, бүлэгтээ мэдлэг, туршлага чанартай хуримтлуулж, хамт олны үйл ажиллагаанд идэвхтэй оролцох оролцоо



Оршихуй: Хүүхэд анги, бүлэг хамт олны дунд үүрэг хариуцлага хүлээж, зан чанар, бусад чадвараараа хүлээн зөвшөөрөгдөх, хүндлэгдэх байдал



Ололт, ахиц гаргах: Идэвх оролцоо, мэдлэг чадварыг сургалтын үнэлгээ болон бусад хүчин зүйлээр үнэлэхэд илрэн гарч буй эерэг өөрчлөлтөөр хэмжигдэх үзүүлэлт

5. ОРОЛЦ

Аливаа үйл хэрэгт оролцож хувь нэмрээ оруулах нь өөрийн болон нийтийн хөгжил, амжилтад хүрэх үндсийг тавьдаг.



Эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, боловсролын салбарын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд ХОЛБОЖ оролцоорой.




Төрийн бус байгууллага, чиглэлийн холбоодын хуримтлуулсан туршлага, санал санаачилгыг түгээн дэлгэрүүлэхэд МАНЛАЙЛЖ оролцоорой.



Боловсрол, сургалтын байгууллага, дэмжлэгийн баг болон хүүхдийн хөгжлийг хангах бусад бүтцүүдтэй ХАМТАРЧ оролцоорой.



ЭЦЭГ ЭХ, ОЛОН НИЙТЭЭС АВСАН СУДАЛГАА • 2022

1 СУДАЛГААНД 18 - 65 НАСНЫ НИЙТ 919 ОРОЛЦОГЧ ХАМРАГДАВ.



ҮГҮЙ 73.7% ТИЙМ 26.3%

4 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эсэх



“Танай хүүхэд ямар төрлийн хөгжлийн бэрхшээлтэй вэ?” гэсэн асуултад дараах байдлаар хариулжээ.



9 Цэцэрлэг, сургуульд хамрагдаж чадахгүй байгаа шалтгааныг тодруулахад дараах байдлаар хариулжээ.

- 4.1% Цэцэрлэг, сургуульд заавал хамруулах шаардлагагүй гэж боддог. Хүүхэд маань сурч, хөгжиж чадна гэдэгт эргэлздэг. 7.3%
- 9.8% Цэцэрлэг, сургуульд хүүхдээ хүргэхэд дэд бүтэц, унаа тээвэр саад болдог. Цэцэрлэг, сургуулийн орчин манай хүүхдэд тохиромжгүй байдаг. 12.2%
- 16.3% Цэцэрлэг, сургуулийн удирдлага, багш нар хүүхдийг маань сургахаас цааргалдаг. Хүүхдийг маань гадуурхаж, шоглох вий гэж эмээдэг. 21.1%
- 52% Бусад

f Тэгш хамруулах боловсролыг дэмжих төсөл

Аливаа үйл хэрэгт оролцож хувь нэмрээ оруулах нь өөрийн болон нийтийн хөгжил, амжилтад хүрэх үндсийг тавьдаг.



Эцэг эхчүүд, тэдний төлөөллийн байгууллагууд хүүхдийнхээ төлөө **НЭГДЭЖ** оролцоорой.



Засгийн газрын бодлого шийдвэр, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг **ХЯНАЖ** оролцоорой.



Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангуулахад **САНУУЛЖ** шаардаж оролцоорой.



Боловсролын талаар баримтлах бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг хангахад **НӨЛӨӨЛЖ** оролцоорой.

СУДАЛГААНД ОРОЛЦОГЧИД ТЭГШ ХАМРАН СУРГАХ БОЛОВСРОЛЫГ ӨРГӨЖҮҮЛЭХЭД ДАРААХ БАЙДЛААР ДЭМЖИН ОРОЛЦОХОО ИЛЭРХИЙЛЖЭЭ.



Эцэг эх, олон нийтээс авсан судалгаа, 2022



Тэгш эрх, ялгаварлан гадуурхалтгүй, хамтдаа сурч хөгжих талаар яриа таниулга хийх, нөлөөллийн ажилд оролцоно.



Тэгш хамран сургах боловсролын талаарх мэдээ мэдээлэл, нөлөөллийн контентыг цахим орчинд дэмжин түгээнэ.



Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн санаачилгаар зохион байгуулагдаж байгаа үйл ажиллагааг дэмжиж биеэр оролцоно.



Тэгш хамран сургах боловсролын талаарх хэвлэмэл хуудсуудыг түгээнэ.

 Тэгш хамруулах боловсролыг дэмжих төсөл

6. ХАМТАР

Олны хүч дэмэндээ, олсны хүч эрчиндээ.

-  Хүүхдийн хөгжлийн төлөвлөгөө, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг БОЛОВСРУУЛАХАД салбар комисс, дэмжлэгийн багтай эхнээс нь ажил хэрэгчээр хамтраарай.
-  Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг үр дүнтэй ХЭРЭГЖҮҮЛЭХЭД багштай хамтарч, хичээлийн бус цагаар хүүхдээ амьдрах ухаан, нийгэмшихүйн чадварт дагуулан сургаарай. Ирээдүйд хүүхэд тань хэн болох нь танаас хамгийн их шалтгаална.
-  Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө хэрхэн хэрэгжсэн, хүүхдэд ямар ахиц өөрчлөлт гарсныг ҮНЭЛЭХЭД бодитой хандаарай. Зөвхөн онолын мэдлэгийн түвшинг хөгжлийн цор ганц хэмжүүр гэж бүү хараарай.
-  Сургалтын байгууллагын хүртээмжтэй орчин, багшийн арга зүй, хамт олны хандлага, хүүхдэд зориулсан хөтөлбөрийн чанар, үр өгөөжийг САЙЖРУУЛАХАД идэвхтэй хандаарай.
-  Хүүхдийн сурч хөгжихөд нь саад болж буй асуудал, бэрхшээлийг илрүүлж, түүнийг арилгах үйлдлийг тодорхой хугацаанд давтамжтай хийж ХЭВШЭЭРЭЙ.



ОНЦГОЙ ХҮМҮҮС

20 дугаар зууны төлөөлөл болох гол уран бүтээлчдийн нэг бол яахын аргагүй Фрида Кахло юм. Алдарт Мексик зураач тэрээр бага насандаа полио өвчөөр өвчилж, өсвөр насандаа осолд орсон нь түүнийг насаараа тэргэнцэр дээр суухад нөлөөлсөн ч тэр хэзээ ч зураг зурахаа болиогүй юм.

Ихэнх үед бие нь хөндүүрлэн өвдөж байсан ч “Зураг зурж чадаж л байвал би амьд байгаадаа үргэлж баяртай байх болно.” гэж хэлсэн нь өнөөдөр ч олон хүнд урам зориг өгсөөр байна.



7. ИТГЭ

Хөгжлийн ялгаатай хүүхдийн боловсрол, нийгэм-шихүйд ахиц дэвшил гарснаар тэд ирээдүйд ажил хөдөлмөр эрхлэн, бие даан амьдрах чадвар, итгэл үнэмшилтэй болдог.

Тэгш хамран сургах боловсролын нотолгооны тухай товч дүгнэлт, Алана институт, 2016



Багш, цэцэрлэг, сургуулиас дан ганц шаардах биш тэдэнтэй нягт хамтран ажиллаж, итгэлцэл түншлэлийг бэхжүүлээрэй.



Хүүхэд тань өөрийн боломжит дээд хэмжээндээ хүртэл суралцаж хөгжсөөр байна гэдэг итгэл хүлээлттэй байгаарай.



Багш, цэцэрлэг, сургууль хүүхдийн тань төлөө идэвх зүтгэл гарган, хичээнгүйлэн ажиллаж байгаа гэдэгт итгээрэй.



Хүүхдийн хувийн онцлогт тохирсон хөтөлбөр, төлөвлөгөө хэрэгжиж, ахиц өөрчлөлт гарна гэдэгт найдаарай.



Цэцэрлэг, сургуулийн дэмжлэгийн баг хүүхэд бүрийн төлөө ажиллана гэдэгт итгээрэй.



Тэгш хамран сургах боловсрол бүх хүнд үнэ цэнийг авч ирдэг гэдэгт итгээрэй.

8. ХУВААЛЦ

...Олон нийтийн ойлголт, хандлагад хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдийн бодит түүх хүчтэй нөлөөлнө гэсэн байр суурь аль ч төсөлд ажиглагдаж байлаа.

Олон нийтэд чиглэсэн цахим контентын судалгаа, 2022



Тэгш хамруулах үйл явц гэр бүлээс эхэлдэг. Гэр бүлийн гишүүд хүүхдийн ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрснөөр нийгэм, хамт олонд оролцох анхны үйлдлээ хийдэг. Хамгийн ойр дотны хүмүүс итгэлгүй байгаа бол бусдаас ойлгохыг шаардаж, шүүмжлэх нь шударга бус юм.



Хүүхэдтэйгээ ажилласан туршлага, сургамжаа арга эвээ хараахан олж амжаагүй байгаа аав, ээжтэй хуваалцаарай.



Хүүхдэдээ гарч буй ахиц өөрчлөлтийг баримтжуулан, хүүдээ охиндоо баяр хүргэн амжилтыг нь тэмдэглэж, сурч хөгжихийн баясгаланг мэдрүүлж байгаарай.



Үр дүнд хүрсэн эмчилгээ засал, арга зүй, хөтөлбөр, хэрэглэгдэхүүн, хэрэгсэл, үйлчилгээний талаарх мэдээллийг аль болох олон хүнд түгээгээрэй.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг бусдын адил сурч хөгжин амжилт гаргана гэдэгт судалгаанд оролцогчдын **74.1%** нь итгэдэг гэжээ.

Эцэг эх, олон нийтээс авсан судалгаа, 2022



✓ Нийгмийн амьдралд хөгжлийн бэрхшээлтэй, бэрхшээлгүй хүмүүс цугтаа оролцох учраас аль болох багаасаа хамт суралцах нь зөв гэж **75.1%** нь үзжээ.

✓ Хүүхдүүд бие биеэ хүлээн зөвшөөрч байвал тэдний л хэрэг шүү дээ гэж **29.8%** нь хариулсан байна.



Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тусгайлан сургах нь илүү дээр гэж **21.9%** нь үзжээ.



Өөрийн хүүхэдтэйгээ хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хамт суралцахад таатай ханддаггүй гэж **9.4%** нь хариулсан байна.

Эцэг эх, олон нийтэд тэгш хамран сургах боловсролын чиглэлээр нөлөөллийн ажил зохион байгуулах шаардлага байсаар байна.

9. САЙЖРУУЛ

Бидэнгүйгээр бидний тухай юм гэж байх ёсгүй.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний оролцоог хангахыг шаардсан ийм нэгэн үг байдаг.



Сайн туршлага хуримтлуулсан орон нутаг, сургалтын байгууллагын нөхцөл байдалтай өөрийн орон нутаг, цэцэрлэг, сургуулийн тэгш хамруулсан үйл ажиллагааг харьцуулан тэднээс байнга суралцаарай.



Боловсролд хамрагдалтыг нэмэгдүүлэх, хүртээмжтэй орчин бүрдүүлэх, тохирох хэрэглэгдэхүүнээр хангах үйл ажиллагааг сайжруулахад хамгийн идэвхтэй оролцогч, дэмжигч, манлайлагч байгаарай.



Тэгш хамруулахтай холбоотой аливаа үйл ажиллагаа зохион байгуулах, үнэлгээ шинжилгээ хийх, өөрчилж сайжруулахад хөгжлийн бэрхшээлтэй хүний санаа бодлыг тусгаж, оролцоог нь заавал хангаж байхыг уриалаарай.

ТҮГЭЭМЭЛ ЗАГВАР



Хүн бүр ашиглах
боломжтой

Уян хатан хэрэглээтэй

Ашиглахад энгийн, хялбар

Шууд ойлгох боломжтой

Биеийн хүч хэт шаардахгүй

Бат бөх, эрсдэлд тэсвэртэй

Хэмжээ, орон зайн хувьд
тохиромжтой

10. УРАМ ЗОРИГ АВ

Хүний амьдралд мөнгө санхүү, ур чадвараас илүү урам зориг хамгийн хүчтэй нөлөө үзүүлдэг.



Хүүхдээ боловсролд тэгш хамруулан, нийгмийн харилцаанд оролцуулж, тэдний төлөө хайр халамжаа зориулж илүү сайхан, эрх тэгш харилцаатай дэлхий ертөнцийг бүтээхэд оруулж буй бодит хувь нэмрээрээ бахархаарай.



Тэгш хамран сургах боловсрол, түүний ач холбогдол, үр өгөөжийг олон нийтэд ойлгуулахад хүчин чармайлт гаргасан үйлдлээсээ урам зориг аваарай.



Нийгмийн хандлагад эергээр нөлөөлөх, эрх зүйн орчныг сайжруулахад хамтран ажилласан талууддаа баяр хүргэн бие биедээ урам зориг нэмээрэй.



Монгол улсын тэгш хамран сургах боловсролын түүхийг бичилцэн, олон улсад нэрлэгдэх сайн туршлага бүтээх хариуцлагатай үйл хэргийг ХАМТДАА хэрэгжүүлцгээе.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ, НОМ ЗҮЙ:

Нэг. Ном, гарын авлага

1. АХБ, БШУЯ, БХАН. 2022. Тэгш хамран сургах боловсрол – Олон нийтэд чиглэсэн цахим контентын судалгаа. Улаанбаатар. (хэвлэгдээгүй)
2. АХБ, БШУЯ, БХАН. 2022. Тэгш хамран сургах боловсролын талаарх бодлогын хураангуй: Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенц (Ерөнхий зөвлөмж No.4) болон Тогтвортой хөгжлийн зорилго 4-ийг дагаж мөрдөх нь. Улаанбаатар. (хэвлэгдээгүй)
3. НҮБ-ын Хүүхдийн Сан. 2014. Тэгш хамран сургах боловсролын талаарх вебинар 1 – Гарын авлагын цуврал: Тэгш хамран сургах боловсролын талаарх үзэл баримтлал болон түүнийг НҮБ-ын Хүүхдийн Сангийн эрхэм зорилгын хүрээнд авч үзэх нь. (UNICEF. 2014. Inclusive Education Webinar 1 – Companion Technical Booklet: Conceptualizing Inclusive Education and Contextualizing it within the UNICEF Mission)

Хоёр. Цахим эх сурвалж

4. АНУ-ын Боловсролын статистикийн үндэсний төв, Товч баримтууд,

<https://nces.ed.gov/fastfacts/display.asp?id=59>

5. Нэгдсэн Үндэстний Байгууллага. 2016. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн талаарх асуудал хариуцсан хороо Ерөнхий зөвлөмж No. 4 (2016) Тэгш хамрагдан сурч боловсрох эрх. CPRD/C/GC 4. Женев. (United Nations. 2016. Committee on the Rights of Persons with Disabilities General Comment No. 4 (2016) on the Right to Inclusive Education. CPRD/C/GC 4. Geneva.)
<https://www.ohchr.org/Documents/HRBodies/CRPD/GC/RighttoEducation/CRPD-C-GC-4.doc>

6. Нэгдсэн Үндэстний Байгууллага. 2016. Тэгш хамрагдан сурч боловсрох эрхийн тухай Ерөнхий зөвлөмж No.4-ийн уншихад хялбаршуулсан хувилбар,

[Easyread_GC_No.4_TheRight_Inclusive_Education.docx \(live.com\)](#)

Гурав. Бусад

7. Паула Ф.Хант, Тэгш хамран сургах боловсрол РР.Т

ISBN 991999630-0



9 789919 999630